

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ

(2022 оны I-р улирлын дүнгийн тухай)

2022 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 2022 оны I-р улирлын байдлаар зохион байгуулан ажиллалаа.

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас нийт 42 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем /<https://erp.ulaanbaatar.mn> /-д бүртгэн, 40 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан бол 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа явагдаж байна. Өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног, 0 цаг, 54 минут.

Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ

Байгууллагад ирсэн өргөдлийг хандалтыг төрлөөр нь ангилбал:

- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл- 15
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл– 7
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл– 3
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл– 9
- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл- 8



График 1. Өргөдлийг төрлөөр нь ангилсан байдал

Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх улиралуудтай харьцуулсан байдал.

Хүснэгт 1

Д/д	Хугацаа	2021.01 улирал	2021.02 улирал	2021.03 улирал	2021.4 улирал	2022.01 улирал
Ерөнхий үзүүлэлт						
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	2 хоног 18 цаг 30 минут	6 хоног 7 цаг 26 минут	4 хоног 15 цаг 59 минут	4 хоног 21 цаг 59 минут	7 хоног, 0 цаг, 54 минут
2	Хандалтын тоо	26	36	54	42	124
3	Зөрчлийн үзүүлэлт	0	0	0	11	2
Өргөдөл гомдлын хандалтын төрөл						
4	Иргэнээс гаргасан санал, хүсэлт	0	0	0	1	0
5	Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл	0	1	0	0	0
6	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл	1	10	10	13	3
7	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл	5	5	5	8	9
8	Захиргааны чөлөө хүссэн өргөдөл	5	2	8	1	7
9	Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл	10	9	10	15	15
10	Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл	3	0	3	14	8

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 0 цаг 54 минут байгаа нь 2021 оны дундаж хугацаанаас буурсан нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т хугацааг баримтлан шийдвэрлэж буйтай холбоотой юм.

Ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан технологийн шийдэл ашиглан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд манай байгууллагад хамааралгүй өргөдөл ирээгүй болно.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Б.ХЭНМЭДЭХ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН
АЖИЛТАН

А.НОМИНЗУЛ